

**Монгол Улсын 2017 оны нэгдсэн
төсвийн Тогтвортой байдал,
Өрийн удирдлагын тойм дүгнэлт**

Нээлттэй Нийгэм Форум

2016



**Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн
Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт**

2016 оны 10 дугаар сар
Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар
Монголын Хөрөнгийн Зах зээлийн Зөвлөл боловсруулав.

Судлаачид;
А.Мөнхцог (MS Econ)
Б.Энхбаяр (MBA)
А.Батпүрэв (MS Econ)

Редактор;
Д.Оюунбадам (PhD)

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
НЭМЭЛТ ТОДРУУЛГА	6
Төсвийн орлого	6
Төсвийн зарлага.....	7
Төсвийн алдагдал ба Засгийн газрын өр	7
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	11
1. ТӨСВИЙН ТЭНЦЛИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	13
1.1 2017 ОН ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА БА ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	13
1.2 ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТУСГАЙ ШААРЛАГУУДАД НИЙЦСЭН БАЙДАЛ	16
1.3 ТӨСВИЙН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ИНДИКАТОРУУД.....	17
А. ТӨСВИЙН УРСГАЛ ТЭНЦЭЛ.....	17
Б. УРСГАЛ ТӨСВИЙН ЗЭЭЛЖИХ ХЭРЭГЦЭЭ	19
В. ӨР ТӨЛБӨР БА ОРЛОГЫН ХАРЬЦАА	19
Г. ЦЭВЭР ЗЭЭЛ	20
2. ӨРИЙН УДИРДЛАГА	21
2.1 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ	21
2.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ДОТООД ӨРИЙН БАЙДАЛ.....	22
А. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС	24
Б. ГАДААД ӨР.....	26
В. ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА	29
2.3 2017 ОНД ШИНЭЭР АВЧ БУЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ	30
2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	31
Гадаад өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд.....	31
Засгийн Газрын нийт өрийн дарамтын үзүүлэлтүүд	32
Зээлжих зэрэглэл ба түүний нөлөөлөл	32
3. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД	34
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	38

График 1. Төсвийн үндсэн үзүүлэлтүүд (сая төг)	14
График 2. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд ДНБ-д эзлэх хувиар	15
График 3. 2017 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалууд	15
График 4. Төсвийн урсгал тэнцлийн байдал	18
График 5. Төсвийн урсгал орлого, урсгал зардал болон ДНБ-ийн өсөлтийн хувь	18
График 6. Төсвийн зээлжих хэрэгцээ (урсгал тэнцлийн зөрүү) сая.төг	19
График 7. Төсвийн өр төлбөр ба орлогын харьцаа (баруун тэнхлэг)	20
График 8. Засгийн Газрын нийт өр	21
График 9. 2010-2017 хооронд ЗГ-ын гаргасан нийт бонд, зээлийн үйлчилгээний төлбөр /их наяд төг/	23
График 10. 2017 онд шинээр авах зээлийн байдал	24
График 11. Дотоодод гаргасан ЗГҮЦ	25
График 12. Дотоодын зах зээлд арилжсан үнэт цаас төсвийн алдагдалын харьцаа	25
График 13. Засгийн Газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй	26
График 14. Дотоод, гадаад Зээлийн үйлчилгээний төлбөрийн харьцаа	26
График 15. Засгийн Газрын гадаад өр	27
График 16. Засгийн Газрын гадаад үнэт цаасны эргэн төлөлт	28
График 17. Засгийн Газрын баталгаа бүхий зээллэгийн эргэн төлөлт /сая ам.доллар/ ..	30
График 18. 2017 онд шинээр болон үргэлжлүүлэн авах хөнгөлөлтэй зээл	30
График 19. Нийт ЗГ-ын өрийн үйлчилгээ ба өрийн үйлчилгээний ДНБ болон тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь /тэрбум төгрөг/	31
График 20. Гадаадын зээл, тусламжийн хөтөлбөрийн тоо салбараар	34
График 21. Гадаадын зээл тусламжийн санхүүжилт салбараар	35
График 22. Зээл тусламжийн хөтөлбөрийг санхүүжүүлэх улс орон, олон улсын байгууллагууд (сая.төгрөг)	36
График 23. Зэл тусламжийн хөтөлбөрүүдийн санхүүжилт төсвийн ерөнхийлөн захирагчдаар	37
Хүснэгт 1. Засгийн Газрын өрийн баталгааны мэдээлэл	29
Хүснэгт 2. Гадаад өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд	32
Хүснэгт 3. Засгийн Газрын нийт өрийн дарамтын үзүүлэлтүүд	32
Хүснэгт 4. Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ	33
Хүснэгт 5. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ ба зээлжих зардлын доод жишиг	33
Хүснэгт 6. Салбар тус бүрт хэрэгжүүлж байгаа төслүүдийг санхүүжилтийн хэмжээ, санхүүжүүлэгч	36

ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ

ААН	-	Аж ахуйн нэгж
ААНОАТ	-	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АХБ	-	Азийн Хөгжлийн Банк
БНХАУ	-	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУ	-	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ГШХО	-	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	-	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	-	Засгийн газар
МУХБ	-	Монгол Улсын Хөгжлийн Банк
НДШ	-	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	-	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУ	-	Олон улс
ОУВС	-	Олон Улсын Валютын Сан
ОХУ	-	Оросын Холбооны Улс
ӨҮЦ	-	Өнөөгийн үнэ цэнэ
СЯ	-	Сангийн Яам
ТӨХК	-	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	-	Улсын их хурал
ХАОАТ	-	Хүн амын орлогын албан татвар
ХБГ	-	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ЭКСИМ банк	-	Экспорт Импорт банк

НЭМЭЛТ ТОДРУУЛГА


2017 оны төсвийн төсөл батлагдах явцад орсон өөрчлөлт

Сангийн Яамнаас өргөн барьсан 2017 оны төсвийн төсөл УИХ-аар батлагдах явцад УИХ-ын гишүүд болон Төсвийн байнгын хорооны хэлэлцүүлгээр тодорхой тооны өөрчлөлтүүд орсон ба ерөнхий агуулгын хувьд төдийлөн томоохон өөрчлөлт ороогүй байна. Өөрчлөлтийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

2017 оны ДНБ-ийг хэлэлцүүлгийн явцад 310.5 тэрбум төгрөгөөр өсгөж 26 их наяд 494 тэрбум төгрөг байхаар батласан ба энэ нь ДНБ-ий өсөлтийг нэмэгдүүлж тооцоолсон гэсэн үг. Төсвийн төсөлд Сангийн Яамны зүгээс эдийн засгийн өсөлтийг 3.4% байхаар төсвийн төсөлд тусгаж ирсэн ба энэ нь Олон улсын санхүүгийн байгууллагуудын таамаглалаас өндөр үзүүлэлт байсан билээ. Гэтэл өсөлтийг дахин өсгөж батласан явдал нь бодит байдалд нийцтэй байх магадлал бага байна.

Төсвийн орлого

2017 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 5,974,798.9 сая төгрөг /5 их наяд 974 тэрбум 798.9 сая төгрөг/ байхаар тооцоолж оруулж ирсэн боловч орлогын хэмжээг 185 тэрбум 389 сая төгрөгөөр буюу 3.1% нэмэгдүүлж батласан байна. Орлогын өсөлтөд:



Татварын орлогын бүрэлдэхүүний өөрчлөлтийг харвал ХАОАТ төсвийн төсөлд тусгагдсанаасаа 5.6 тэрбум төгрөгөөр буюу төслөөс 1 хувиар өсч, ААНОАТ төслөөсөө 4.3 тэрбумаар буюу 0.9 хувиар буурч батлагдсан. Татварын орлогын өсөлтийн 46% буюу 36 тэрбум төгрөгийг НӨАТ, 20%-ийг гаалийн албан татвар, 14%-ийг НДШ, 18%-ийг бусад татвар хураамжийн орлого бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл НДШ-ийн орлогыг өсгөж батласан нь төсвийн орлогын нэмэгдүүлж тооцоох боломжийг олгосон байна.

Татварын бус орлогын бүрэлдэхүүнийг авч үзвэл татварын бус орлогын нэмэгдүүлэлтийн 47%-ийг хөрөнгийн орлого, 43%-ийг нийтлэг бус татварын орлого бүрдүүлж байгаа ба хөрөнгийн орлого /өмч хувьчлалаас орох/ төсвийн төсөлд туссан хэмжээнээсээ 50 тэрбум төгрөг буюу 39.2% нэмэгдэж батлагдсан. Төсвийн орлого ДНБ-ий 23.3% байхаар батлагдсан нь төсвийн төслийн тооцооллоос 0.4% доогуур үзүүлэлт юм.

Төсвийн зарлага

2017 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад төсвийн зардлыг бууруулах талаар мэргэжлийн байгууллагууд, шинжээчид саналаа илэрхийлж, бодлогын түвшинд хэлэлцэж байсан боловч урсгал зардлын хэмжээг 0.2% буюу 10.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж батласан.

Урсгал зардал +10,505.2
сая /+0.2%/

- Цалин хөлс -0.4%
- Бараа үйлчилгээний зардал +1.8%
- Зээлийн үйлчилгээний төлбөр -0.6%
- Урсгал шилжүүлэг +0.1%


Хөрөнгийн зардал -
10,268.1 сая
/-0.7%/

- Барилга байгууламж +2.2%
- Их засвар +2.9%
- Тоног төхөөрөмж +9.1%
- Бусад хөрөнгө -6.2%
- Стратегийн нөөц хөрөнгө +0.3%

Төсвийн зардлын хамгийн өндөр таналтыг хөрөнгийн зардлын бусад хөрөнгө гэсэн зардлын ангилалд багтах хөрөнгийн зардлыг 32.9 тэрбум төгрөгөөр бууруулж, эсрэгээрээ бараа үйлчилгээний зардлын хэмжээг 23.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж өгсөн нь төсвийн зардлыг бууруулах чиглэлд доривтой өөрчөлтийг оруулж чадаагүй байна. Зардлын бүрэлдэхүүнд хамгийн өндөр өсөлтийг тоног төхөөрөмжийн зардалд /+9.1%/ гаргасан ба харин хамгийн өндөр таналтыг бусад хөрөнгийн зардалд гарсан байна. Бусад зардлын бүрэлдэхүүн хэсгүүдэд төсвийн төслийн тооцооллоос дунджаар 2 хүртэл хувийн өөрчлөлт орсон байна. Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу. Ийнхүү батлагдсан 2017 оны төсвийн зардлын хэмжээ нь ДНБ-ий 32.3% буюу төсвийн төслийн тооцооллоос 0.4% буурсан үзүүлэлт юм.

Төсвийн алдагдал ба Засгийн газрын өр

2017 оны төсвийн төсөлд тооцоолсон төсвийн алдагдлын хэмжээг 7% бууруулж 2,408,692.5 сая /2 их наяд 408 тэрбум 692.5 сая төгрөг/ байхаар 2017 оны төсвийг УИХ батласан. Энэ нь ДНБ-ий 9.09% буюу төсвийн төслийн тооцооллоос 0.8% доогуур үзүүлэлт юм. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсврийн хувьд 2017 онд шинээр нэмэгдэх ЗГ-ын үнэт цаасны хэмжээ 477.3 тэрбум төгрөгөөр буюу 16.1% буурч батлагдсан. Энэ нь ЗГ-ын өрийн дарамтыг бууруулах чиглэлд ахиц юм. ЗГ-ын үнэт цаасыг задлан авч үзвэл ирэх онд /2017 он/ дотоодын зах зээлд гаргахаар төлөвлөж буй урт хугацаат ЗГ-ын үнэт цаасны хэмжээг 564.3 тэрбум буюу төсвийн төсөлд тооцоолсноос 12.1% бага үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргахаар, харин олон улсын зах зээлд гаргахаар төлөвлөж буй үнэт цаасны хэмжээ 87 тэрбумаар буюу 6.7% нэмэгдүүлж тооцон батласан байна.



Зээлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг 8.3 тэрбум төгрөгөөр буюу -0.6% бууруулж батласан ба энэ нь ДНБ-ий 5.08% буюу төсвийн төсөлд танилцуулсан 5.17%-ийн түвшингээс 0.09% доогуур үзүүлэлт юм. Төсвөөс эргэн төлөгдөх зээлийн төлөлтийг 2017 оны төсвийн төсөлд тооцсон түвшингээс нэмэгдүүлж 1,219,205.1 сая төгрөг буюу 87 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.

ХАВСРАЛТ

2017 оны төсвийн төсөл өргөн барьсан болон батлагдсан байдал /сая төгрөг/

	Өргөн барьсан	Батлагдсан	Өөрчлөлт	Өөрчлөлт /хувнар/
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,195,411.7	6,390,236.7	194,825.0	3.1%
Тогтворжуулалтын сан	12,492.9	8,397.8	(4,095.1)	-32.8%
Ирээдүйн өв сан	208,120.0	221,651.0	13,531.0	6.5%
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,974,798.9	6,160,187.9	185,389.0	3.1%
1. Татварын орлого	4,905,613.0	4,983,804.2	78,191.2	1.6%
1.1. Орлогын албан татвар	1,055,027.8	1,056,270.7	1,242.9	0.1%
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	555,247.4	560,819.9	5,572.5	1.0%
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	499,780.4	495,450.9	(4,329.5)	-0.9%
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0	0	-	
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,163,210.8	1,174,330.0	11,119.2	1.0%
1.3. Өмчийн татвар	63,852.9	63,852.9	-	0.0%
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,237,974.7	1,273,946.8	35,972.1	2.9%
1.5. Онцгой албан татвар	547,208.2	547,208.2	-	0.0%
1.6. Тусгай зориулалтын орлого	44,242.4	44,205.8	(36.6)	-0.1%
1.7. Гаалийн албан татвар	380,016.4	395,788.6	15,772.2	4.2%
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	414,079.9	428,201.2	14,121.3	3.4%
2. Татварын бус орлого	1,069,185.9	1,176,383.7	107,197.8	10.0%
2.1. Нийтлэг бус татварын орлого	806,929.1	853,331.9	46,402.8	5.8%
2.2. Хөрөнгийн орлого	127,700.8	177,700.8	50,000.0	39.2%
2.3. Тусламжийн орлого	134,556.0	145,351.0	10,795.0	8.0%
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	0	-	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	8,564,014.9	8,568,880.3	4,865.4	0.1%
А. УРСГАЛ ЗАРЛАГА	6,937,333.7	6,947,838.9	10,505.2	0.2%
1. Бараа, үйлчилгээний зардал	3,026,446.6	3,043,150.0	16,703.4	0.6%
1.1. Цалин, хөлс	1,742,173.9	1,735,717.9	(6,456.0)	-0.4%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0	0	-	
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,284,272.7	1,307,432.0	23,159.3	1.8%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	1,354,069.9	1,345,740.0	(8,329.9)	-0.6%
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,556,817.1	2,558,949.0	2,131.9	0.1%
3.1. Татаас	191,006.6	191,006.6	-	0.0%
3.2. Урсгал шилжүүлэг	2,365,810.6	2,367,942.4	2,131.8	0.1%
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,494,153.0	1,483,884.9	(10,268.1)	-0.7%
1. Барилга байгууламж	621,334.4	634,794.3	13,459.9	2.2%
2. Их засвар	55,768.7	57,370.0	1,601.3	2.9%
3. Тоног төхөөрөмж	82,403.0	89,864.5	7,461.5	9.1%
4. Бусад хөрөнгө	530,095.8	497,219.8	(32,876.0)	-6.2%
5. Стратегийн нөөц хөрөнгө	31,756.2	31,841.3	85.1	0.3%
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	172,794.9	172,794.9	-	0.0%
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	132,528.2	137,156.5	4,628.3	3.5%
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-38,196.9	-44,950.3	(6,753.4)	17.7%
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	170,725.2	182,106.8	11,381.6	6.7%

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-2,589,216.0	-2,408,692.5	180,523.5	-7.0%
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,589,216.0	2,408,692.5	(180,523.5)	-7.0%
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	0	0	-	
2. ЗГ-ын үнэт цаас	2,955,279.2	2,478,022.7	(477,256.5)	-16.1%
2.1. Урт хугацаат	2,955,279.2	2,478,022.7	(477,256.5)	-16.1%
2.1.1. Дотоод	1,650,279.2	1,086,022.7	(564,256.5)	-34.2%
2.1.1.1. Шинээр гаргах	4,674,207.2	4,109,950.6	(564,256.6)	-12.1%
2.1.1.2. Үндсэн төлбөр	-3,023,927.9	-3,023,927.9	-	0.0%
2.1.2. Гадаад	1,305,000.0	1,392,000.0	87,000.0	6.7%
2.1.2.1. Шинээр гаргах	1,305,000.0	1,392,000.0	87,000.0	6.7%
2.2. Богино хугацаат	0	0	-	
2.2.1. Дотоод	0	0	-	
2.2.1.1. Шинээр гаргах	729,489.4	729,489.40	-	0.0%
2.2.1.2. Үндсэн төлбөр	-729,489.4	-729,489.4	-	0.0%
3. ЗГ-ын зээл	-526,063.2	-559,018.9	(32,955.7)	6.3%
3.1. Дотоод	-1,084,085.1	-1,157,554.1	(73,469.0)	6.8%
3.1.1. Авлага	48,120.0	61,651.0	13,531.0	28.1%
3.1.1.1. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	48,120.0	61,651.0	13,531.0	28.1%
3.1.2. Төсвөөс эргэн төлөгдөх	-1,132,205.1	-1,219,205.1	(87,000.0)	7.7%
3.1.2.1. Авах	172,794.9	172,794.9	-	0.0%
3.1.2.2. Төлөх	-1,305,000.0	-1,392,000.0	(87,000.0)	6.7%
3.2. Гадаад	558,021.9	598,535.2	40,513.3	7.3%
3.2.1. Төслийн зээл	558,021.9	598,535.2	40,513.3	7.3%
3.2.1.1. Шинээр авах	723,121.9	770,223.0	47,101.1	6.5%
3.2.1.2. Үндсэн төлбөр	-165,100.0	-171,687.8	(6,587.8)	4.0%
4. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	160,000.0	160,000.0	-	0.0%

2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТЭНЦЭЛ:

- Орлогын өөдрөг төсөөлөл дээр үндэслэн хэмнэлтийн зарчмаар төсөв боловсруулсан гэх боловч хөрөнгө оруулалтын зардлыг 855 тэрбум төгрөгөөр бууруулж урсгал зардлыг 220 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Төсвийн төсөлд тусгагдсан голлох индикаторууд тогтворгүй буюу урсгал орлого, зардал, өр зээлийн хэмжээ нь жил бүр өөрчлөгддөг тогтворгүй байна. Урсгал орлого нь урсгал зардлаа санхүүжүүлэх чадваргүй байгаа нөхцөлд урсгал зардлыг нэмэгдүүлж тооцсон нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлж, урт хугацаанд төсөвт учруулах өрийн дарамтыг нэмэгдүүлж байна.
- Татварын бүх хэлбэрийн орлогын төсөөллийг нэмэгдэнэ гэж тооцолсон боловч татвар төлөгчийн тоо 4.1 хувиар буурсан нь нэг татвар төлөгчид оногдох татварын дарамт нэмэгдэж 402 мянган төгрөг болж байна.
- ЗГ-аас гаргасан хувьчлах байгууллагуудын үнэлгээ нь бодитой бус буюу тодорхой үндэслэл гаргаагүй.

Учирч болох эрсдэл:

- Төсвийн орлогын 81 орчим хувь нь татварын орлогоос бүрдэж байгаа нь төсвийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт саарсан, гадаадын хөрөнгө оруулалт буурсан үед татварын орлого, тэр дундаа ААНОАТ, гаалийн татвар зэрэг татвараас олох орлогын хэт өөдрөг төсөөлсөн байдал нь эрсдэлтэй байна.
- Өмнөх жилүүдтэй харьцуулахад ААНОАТ-ын төсвийн орлогод эзлэх хувь огцом буурч, ХХОАТ болон НДШ-ийн хураамжийн орлогууд нь илүү жин дарах болсон. Эдийн засгийн хүндрэлтэй үед буюу 2016 онд ААН-ийн ашигт ажиллагаа буурсан ч ажлын байрыг тогтвортой хадгалж чадсан байна. Гэсэн хэдий ч эдийн засаг сэргэхгүй бол урт хугацаанд ажлын байрыг тогтвортой хадгалах боломжгүй нөхцөл байдал үүссэн үед ХХОАТ болон НДШ-ийн хураамжийн орлого буурах эрсдэлтэй байна.
- Уул уурхайгаас олох орлогын тооцохдоо гол түүхий эдүүдийн үнийн түвшинг Дэлхийн зах зээлээс бага зэрэг доогуур үнээр тооцсон боловч олборлолтын буюу экспортын хэмжээг хэт өсгөж тооцсон нь УУ-с хамааралтай манай эдийн засгийн хувьд маш эрсдэлтэй байдлаар төсвийн орлогыг тооцсон байна.
- Бүхэлдээ 2017 оны төсвийн төслийн орлогын тооцоолол, таамаглал, төсөөллүүд нь хэт өөдрөг буюу бодит бус байдлаар тооцоолсон, уялдаагүй байдал нь төсвийн алдагдал тооцсоноос илүү өндөр гарах, эдийн засгийн өсөлт тооцсон хэмжээнд хүрэхгүй байх зэрэг эрсдлүүдийг үүсгэж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАЙДАЛ

- Сүүлийн 3 жилд нэгдсэн төсвийн алдагдлын 50+ хувийг зээлийн үйлчилгээний төлбөр эзэлж байна.
- 2017 оны төсвийн төсөлд тусгаснаар ЗГ нийт 7.6 их наяд төгрөгийн дотоод гадаадын зээл авах ба үүний 69 хувийг Засгийн Газрын өрийн үндсэн төлбөр төлөхөд, үүн дотроо 50%-ийг дотоодын зах зээл дээр гаргасан үнэт цаасны үндсэн

төлбөрийг төлөхөд, 33 орчим хувийг төсвийн алдагдал санхүүжүүлэхэд зарцуулах дүр зураг харагдаж байна.

- Өмнөх онуудын төсвийн алдагдал дотоодын зах зээлд арилжсан үнэт цаасны харьцааг харахад дотоодын зах зээл дээр арилжигдах Засгийн Газрын бондоор төсвийн алдагдлыг нөхөхөөс илүүлтэйгээр өмнөх үеийн үнэт цаасны төлбөрүүдийг гүйцэтгэж ирсэн байна.
- Монгол улс 2012 оноос хойш олон улсын зах зээл дээр 3 удаа үнэт цаас гаргасан ба ирэх 2018, 2021, 2022 онуудад үндсэн төлбөрийн төлөлт хийгдэх хуваарьтай байна. Эдгээр үндсэн төлбөрүүд нь ирэх жилүүдэд төсөвт өрийн ачааллыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байна.

ЭРСДЭЛ

- Төсвийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр дорвитой ажлууд хийхгүй, төсвийн сахилга батыг чангатгахгүй байх тохиолдолд дотоодын зах зээл дээр ЗГ-ын үүсгэж буй өрийн хэмжээ буурах төсөөлөл харагдахгүй байна. Өмнөх өрөө дахин санхүүжүүлэх замаар /дотоод бонд гаргах замаар/ төлөх байдлаар цааш үргэжлэх тохиолдолд ЗГ-ын гадаад өрөөс илүүтэйгээр дотоод өрийн дарамтад орох магадлал өндөр байна.
- Сүүлийн жилүүдэд нийт өрийн үйлчилгээний төлбөр улсын тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь үлэмж нэмэгдэж байгаа ба энэ нь төсөвт ирэх өрийн дарамтыг улам нэмэгдүүлж, өрийг өрөөр хаах сонголтыг үлдээх, улмаар санхүүжилтийн зардал өсөх, өрийн дарамт гүнзгийрэх нөхцлийг бүрдүүлэх эрсдэл өндөр байна.
- Өрийн үйлчилгээ төсвийн орлогын харьцаа ирэх онуудад өндөр байгаа нь Засгийн Газар өрөө шинэчлэх эсвэл өөр эх үүсвэрийн зээлээр өмнөх өрөө дарахаас өөр сонголтгүй байгаа нь харагдаж байна. Энэ тохиолдолд хүүгийн зардал өсөх ба өрийн дарамт нэмэгдэх өндөр эрсдлийг дагуулж байна.

ЗӨВЛӨМЖ

- 2017 оны төсвийн төслийн орлогын төсөөллийг бодитойгоор тооцох.
- 2017 оны төсвийн төслийн урсгал зардлыг бууруулах.
- Урт хугацаанд төсвийн орлогын бүтцийг өөрчилж олон эх үүсвэртэй болгох.
- Тусгай сангуудын ашиглалт, менежментийг сайжруулж, өөрийгөө санхүүжүүлэх чадавхитай болгох.
- Засгийн Газрын өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх ачааллыг урт хугацаанд жигдлэх.
- Өрийн үйлчилгээний тухайн жилийн төсвийн орлогод эзлэх хувь хэмжээг бууруулах.
- Засгийн Газрын өрийн эргэн төлөлтийн хугацааг уртасгах.
- Монгол Улсын зээлжих зэрэглэл, төлөвийг сайжруулах.
- 2021, 2022 онд хугацаа дуусах гадаад үнэт цаасуудын төлбөрийг төлөх хөтөлбөр, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж жил бүрийн төсөвт тусгаж явах нь оновчтой болно.
- Дотоодын зах зээлд гарч буй үнэт цаасыг гадаадын урт хугацаат үнэт цаасаар дахин санхүүжүүлэх.

1. ТӨСВИЙН ТЭНЦЛИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Төсөв нь төр засгийн үйл ажиллагааны жил тутмын санхүүжилтийн хуваарьлалт, түүний эх үүсвэрийг тодорхойлсон богино хугацааны бодлогын баримт төдийгүй дунд болон урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих төрийн үйл ажиллагаа буюу сангийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь юм.

Иймээс төсвийн бодлого нь урт хугацааны тогтвортой хөгжлийн (sustainable development) үзэл баримтлалд нийцсэн байх учиртай. Үүний тулд төсвийн төлөвлөлтөд дараах гол зарчмуудыг мөрдлөг болгох шаардлагатай гэж үздэг. (Sustainable budget commission , 2009)


- **Санхүүгийн тогтвортой байдал:** Засгийн Газрын одоо болон ирээүүд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа нь төсвийн чадавхи, тэнцлийн байдлын улмаас доголдож санхүүгийн эрсдэлд орохгүй байх
- **Татварын тогтвортой байдал:** Татвар, орлого бүрдүүлэлтийн бусад систем нь гэнэтийн өөрчлөлтгүйгээр тогтвортой үргэлжилж эдийн засгийн өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмждэг байх
- **Үе хоорондын тогтвортой байдал:** Нөөц баялгийн ашиглалт, хуваарилалт болон татварын орлогын бүрдүүлэлт нь нийгмийн үе хооронд “шударга” тэгш хуваарилагддаг байх
- **Бодлого, хөтөлбөрийн тогтвортой байдал:** Бодлогын тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүд тууштай хэрэгждэг байх
- **Нийгмийн тогтвортой байдал:** Боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдал гэх мэт нийгмийн зорилтууд үе шаттай хэрэгжих баталгаа төсөв хангах ёстой бөгөөд хэрэгжилтийг үнэлэхэд хамгийн төвөгтэй үзүүлэлт

Эдгээрээс төсвийн санхүүгийн тогтвортой байдал нь Засгийн Газар гадаад орчны аливаа шоконд хариу үйлдэл үзүүлж макро эдийн засгийг удирдах, бодлого хөтөлбөр, үе хоорондын урт хугацааны тогтвортой байдлаа хадгалах гол нөхцөл болдог. Иймд энэ судалгааны ажлын хүрээнд 2017 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн санхүүгийн тогтвортой байдлыг тэнцлийн индикаторууд, өрийн удирдлагын үзүүлэлтүүдээр тоймлон шинжиллээ.

1.1 2017 ОН ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА БА ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2017 оны 9-р сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан төсвийн төсөлд тусгаснаар төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 5.98 их наяд төгрөг буюу 2016 оны төсвийн тодотголоос 626,58 тэрбум төгрөгөөр илүү, зардлыг 8.56 их наяд төгрөг буюу 1.1 их наяд төгрөгөөр бууруулан төсөвлөсөн байна.

График 1. Төсвийн үндсэн үзүүлэлтүүд (сая төг)




Эх сурвалж; Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Сангийн яам 2016

Нийт төсвийн орлогын 79.2% буюу 4.9 их наяд төгрөгийг татварын орлогоос, 17.3% буюу 1.07 их наяд төгрөгийг татварын бус орлогоос, 2.8% буюу 0.14 их наяд төгрөгийг тусламжийн орлогоос тус тус бүрдүүлэхээр тооцсон ба нийт тэнцвэржүүлсэн орлогын 82.1% буюу 4,9 их наяд төгрөгийг татварын орлого, үлдэх 17.9% буюу 1,06 их наяд төгрөгийг татварын бус орлого бүрдүүлэхээр байна.

2017 төсөвт уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс төсөвт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор гол нэр төрлийн эрдэс баялаг болох зэсийн тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнийн зөрүүгээс үүсэх орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 65 хувийг Ирээдүйн өв санд тус тус төвлөрүүлэхээр тооцсон ба Төсвийн тогтворжуулалтын сангаас 12.49 тэрбум төгрөг, Ирээдүй өв сангаас 208.12 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар төсөлд тусгасан.

Нийт зардлын 81% буюу 6.94 их наяд төгрөгийг урсгал зардалд, 17.4% буюу 1.5 их наяд төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар тооцсон ба өмнөх 2016 оныхоос урсгал зардал 220 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн боловч хөрөнгийн зардлыг 856 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөжээ.

График 2. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд ДНБ-д эзлэх хувиар




Эх сурвалж; Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Сангийн яам 2016

Төсвийн алдагдлыг Нэрлэсэн ДНБ-ий 9.9% буюу 2.6 их наяд төгрөг байхаар тооцон төсөвлөсөн бөгөөд нэрлэсэн ДНБ-ийг 26.18 их наяд төгрөгт хүрч 2016 оны төсвийн тодотголоос 8.2% буюу 1.98 их төгрөгөөр өсөхөөр төсөөлсөн байна.

Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2016 оны тодотоголын түвшингээс 7 хувиар буурч тэнцвэржүүлсэн цэвэр орлогын ДНБ-нд эзлэх хувь 1.6 хувиар өсөхөөр төлөвлөсөн. Гэсэн хэдий ч төсвийн орлогын төсөөлөл нь зарим талаар ихээхэн өөдрөг хүлээлтэд суурилсан байгаа нь тасалдах эрсдэл бий.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2017 онд Дэлхийн банк 2.7 хувь, Олон улсын валютын сан 2.5 хувь, Азийн хөгжлийн банк 1.4 хувь байна гэсэн таамаглалуудыг дэвшүүлсэн бол Сангийн яам 3.4 хувиар өсөх тооцоонд үндэслэн 2017 оны төсвийн төслийг боловсруулсан байна.

График 3. 2017 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалууд



Эх сурвалж; Сангийн яам 2016, Дэлхийн банк, ОУВС, АХБ

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт

1.2 ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТУСГАЙ ШААРЛАГУУДАД НИЙЦСЭН БАЙДАЛ

2010 оны 06 сарын 24 өдөр батлагдсан “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулиар төсвийн тогтвортой байдал гэдэг ойлголтыг дараах байдлаар хуульчилсан байдаг:

- 6.1.1. нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;
- 6.1.2. нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;
- 6.1.3. тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;
- 6.1.4. Засгийн Газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.

Сангийн Яамны боловсруулсан танилцуулгаас үзэхэд 2017 оны төсвийн төслийг боловсруулахдаа эдгээр шаардлагуудад нийцүүлэн төлөвлөсөн байна.

Гэхдээ Төсвийн тогтвортой байдлын 2 болон 4 дүгээр тусгай шаардлагыг тус хуулийн 19 дүгээр бүлэгт заасны дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэхээр 2016 оны 9 дүгээр сарын 09-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар баталсан байдаг. Иймд 2017 онд төсвийн тэнцлийн алдагдлын дээд хэмжээ ДНБ-ий 10 хувиас илүүгүй, Засгийн Газрын нийт өрийн өнөөгийн үнэ цэнэ ДНБ-ий 85 хувиас ихгүй байхаар тооцжээ.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.

2017 онд зэсийн баяжмалын экспортоос төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3 хувиас давна гэж төсөөлж “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д заасны дагуу зэсийн үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон.

Цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 4,599 ам.доллар, зах зээлийн үнийг 4,800 ам.доллар байхаар тооцож, Тогтворжуулалтын санд нийт 7.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал тухайн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй байх.

2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5,974.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 22.8 хувь, нийт зарлага 8,564.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.7 хувь, нийт алдагдал 2,589.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 9.9 хувь байгаа нь хуулийн үнсэн шаардлагад нийцээгүй хэдий ч дагаж мөрдөх журмын тухай 19 дүгээр бүлгийн зохицуулалтад нийцүүлсэн.

Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.

2016 оны эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 7.0 хувьтай, 2005-2016 оны эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж 22.5 хувьтай тус тус гарсан байна. 2017 оны төсвийн төсөлд нийт зарлагын дээд хэмжээг 8,564.0 тэрбум төгрөгөөр тооцож, нийт зарлагын өсөлт -11.7 хувь буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан тусгай шаардлагыг хангасан.

Засгийн Газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь 2017 онд ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх.

Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн төсөлд туссан Засгийн Газрын шинээр авах зээл, гаргах үнэт цаас, өрийн баталгаа, тэдгээрийн эргэн төлөлт болон Засгийн Газрын өрийн удирдлагын бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээг оруулан тооцсоноор 2017 оны эцэст Засгийн Газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 84.8 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн Газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг (19.6-д зааснаар) хангасан гэж Засгийн Газар үзсэн байна.

1.3 ТӨСВИЙН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ИНДИКАТОРУУД

Төслийн санхүүгийн тогтвортой байдал нь улс орнуудын хувьд ихээхэн чухал үзүүлэлт бөгөөд төсвийн тогтвортой байдлыг илтгэх хүчин зүйлүүд нь улс орон бүрт харилцан адилгүй боловч нийтлэг хүчин зүйл нь урсгал орлого болон урсгал зардал, зарцуулалтын үр өгөөж, түүнийг санхүүжүүлж буй хэлбэр, тэдгээрийн хоорондын хамаарал нь урт болон богино хугацаанд улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж чадах эсэхийг илэрхийлэх ач холбогдолтой юм.

Хөгжингүй орнуудын тухайд төсвийн тогтвортой байдлыг илүү олон үзүүлэлтээр хэмждэг байна. Тиймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын хуулинд тусгасан үзүүлэлтүүдээс гадна бусад улс орны төсвийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийг багтааж дараах индикаторуудаар Монгол Улсын 2017 оны төсвийн төсөлд шинжилгээ хийсэн болно.

- a. Төсвийн урсгал тэнцэл
- b. Урсгал төсвийн зээлжих хэрэгцээ
- c. Төсвийн өр төлбөр ба орлогын харьцаа
- d. Цэвэр өр


A. ТӨСВИЙН УРСГАЛ ТЭНЦЭЛ

Улс орны санхүүгийн тогтвортой байдлыг илтгэх суурь хүчин зүйл нь урсгал орлого болон урсгал зардлын тогтвортой байдал ба урсгал тэнцлийн алдагдал юм. Өөрөөр хэлбэл богино, дунд болон урт хугацаанд улс орны санхүүгийн чадавхи, орлогоороо зардлаа санхүүжүүлэх чадвартай байдлыг хэмжинэ.

Монгол Улсын 2003-2016 онуудын төсвийн урсгал тэнцэл 2014 оноос хойш алдагдалтай, урсгал орлого тогтмол буурч байгаа боловч урсгал зардал нэмэгдэж, 2016 оны төсвийн тодотголд урсгал орлого өмнөх оноос 12% буюу 600 тэрбум төгрөгөөр буурахаар тооцсон боловч урсгал зардал 998 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2015 оноос 3.7 дахин их, ДНБ-ий 7.8%-тай тэнцэх буюу 2 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар тооцсон байна.

2015-2016 онд төсвийн урсгал орлого буурахад ААН-ийн орлого (-254 тэрбум төгрөг) болон Бусад татвар хураамжийн орлого (-354 тэрбум) буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна.


График 4. Төсвийн урсгал тэнцлийн байдал



Эх сурвалж; Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Сангийн яам 2016

2017 оны төсвийн төсөлд урсгал орлогыг нийт 4.9 их наяд төгрөг буюу 395 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ гэж тооцолсон боловч урсгал зардлыг 220 тэрбум төгрөгөөр өсгөж, урсгал задлын тэнцлийг 2 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар төсөвлөжээ. Сүүлийн 3 жил урсгал орлого буурч байгаа нөхцөлд урсгал зардлыг өсгөж тооцож байгаа нь учир дутагдалтай бөгөөд гол нэрийн экспортын бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээлд дээр буурч байгаа, эдийн засгийн хүндрэлтэй үед тэнцлийн алдагдал төлөвлөснөөс илүү гарах магадлалтай байна.

График 5. Төсвийн урсгал орлого, урсгал зардал болон ДНБ-ийн өсөлтийн хувь



Эх сурвалж; Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Сангийн яам 2016

Монгол Улсын урсгал орлого зардал нь тогтворгүй, өөрчлөлтийн дээд түвшин нь 65.9%, бага нь 0.7%-иар өөрчлөгдөж, 2003 оноос тогтворгүй явж ирсэн ба 2013 оноос тогтворжих хандлагатай болсон. Төсвийн урсгал тэнцлийн тогтворгүй байдал нь ДНБ-д шууд нөлөөлдөг байна.


Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт

Б. УРСГАЛ ТӨСВИЙН ЗЭЭЛЖИХ ХЭРЭГЦЭЭ

Төсвийн урсгал орлогоор урсгал зардлаа санхүүжүүлж чадахгүй нөхцөлд зөвхөн урсгал зардлыг санхүүжүүлэх зорилгоор зайлшгүй авах зээлийн хэрэгцээ юм. Зээлжих хэрэгцээг тооцохдоо Төсвийн урсгал тэнцлээс хөрөнгө оруулалтын зардлыг хасаж тооцсон болно.

2017 оны төсвийн төсөлд нийт 8.56 их наяд буюу ДНБ-ийн 32.7%-тай тэнцэх хэмжээний төгрөгийн зарлага төлөвлөсөн ба үүнээс урсгал зардалд 6.38 их наяд төгрөг, хөрөнгийн зардалд 1.49 их наяд төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 0.13 их наяд төгрөгийг зарцуулахаар тооцсон байна.

График 6. Төсвийн зээлжих хэрэгцээ (урсгал тэнцлийн зөрүү) сая.төг



Эх сурвалж; Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Сангийн яам 2016


Монгол Улсын хувьд 2003-2010 онуудад төсвийн урсгал зардлаа зээлээр санхүүжүүлдэг байсан бол 2010 оноос хойш зээлийн санхүүжилтээр урсгал зардлаас гадна хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлж эхэлсэн. 2016 оны байдлаар 2.4 их наяд төгрөгийн зээлээр урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн бол 2017 оны улсын төсвийн төсөлд ДНБ-ий 5.2%-тай тэнцэх хэмжээний буюу 1.4 их наяд төгрөгийн зээлээр урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэхээр тооцсон байна. Засгийн Газар хөрөнгө оруулалтын зардлыг өмнөх оныхоос 855 тэрбум төгрөгөөр бууруулсан боловч урсгал зардлыг бууруулахгүйгээр зээлээр санхүүжүүлэхээр төсөвлөсөн байдал нь дунд болон урт хугацаанд төсөвт учруулах өрийн дарамтыг нэмэгдүүлэхээр байна.

В. ӨР ТӨЛБӨР БА ОРЛОГЫН ХАРЬЦАА

Төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх цэвэр зээлийн харьцаа нь улсын төсөвт учруулж байгаа санхүүгийн өр төлбөрийн дарамтыг илэрхийлэх үзүүлэлт юм. Харьцаа нь өндөр байвал урсгал орлогод учрах өр төлбөрийн дарамт өндөр буюу өр төлбөрөө төлөх чадвар сул байгааг илэрхийлдэг бол энэ харьцаа нь бага буюу 0 рүү тэмүүлэх тусам өрийн дарамт бага, өр төлбөрөө барагдуулах чадвар сайн гэж үздэг байна. Мөн энэхүү харьцаа хугацааны дагуу нь тогтмол байх нь улсын төсвийн тогтвортой байдлыг илэрхийлэх үзүүлэлт болох юм.

Монгол Улсын 2003–2016 оны төсөвт хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад төсвийн урсгал зардал урьд жилүүдийнхээс өндрөөр нэмэгдсэн жилд төсөвт учрах өр төлбөрийн дарамт нэмэгддэг хандлага ажиглагдсан, Жишээ нь 2011 онд 48%-иар өсөхөд харьцаа 0.11 (11%) хүрсэн бол 2016 онд мөн 0.12 (12%) пункт болж өссөн. Эдгээр жилүүдэд цэвэр зээлийн хэмжээ нэмэгдсэн байна.

График 7. Төсвийн өр төлбөр ба орлогын харьцаа (баруун тэнхлэг)



Эх сурвалж; Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Сангийн яам 2016

2017 оны төсвийн төсөлд өр төлбөр ба орлогын харьцааг -0.02 болж буурахаар тооцсон боловч эдийн засгийн хүндрэлтэй байгаа үед урсгал орлогын хэт өөдрөг төсөөлөл нь биелэхгүй байх магадлал өндөр, урсгал зардлыг өсгөж төлөвлөсөн тул санхүүжилтийн дутагдал үүсч уг харьцаа илүү өндөр гарах магадлалтай.

Г. ЦЭВЭР ЗЭЭЛ

Төсвийн буюу Засгийн Газрын өр зээлийн үзүүлэлтүүдээр дараагийн бүлэгт дэлгэрэнгүй шинжилгээ хийсэн.

2. ӨРИЙН УДИРДЛАГА

2.1 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Засгийн Газар нь төсвийн алдагдал нөхөх, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхийн тулд олон улсын зах зээл болон дотоодын зах зээлд үнэт цаас гаргах эсвэл олон улсын банк санхүүгийн байгууллага, донор улс орнуудаас зээл авах замаар өр үүсгэдэг.

Засгийн Газрын өрийг дотоод болон гадаад өр гэж ангилан авч үздэг ба дотоод өр гэдэг нь тухайн улсад байгаа зээлдүүлэгчдийн эзэмшиж буй өр, гадаад өр гэдэг нь гадаад улс орнуудад байгаа зээлдүүлэгч нарын эзэмшиж буй нийт өрийн дүн юм.


Засгийн Газрын өр гэж:

4.1.8. а/өрийн хэрэгслээр үүсгэж Монгол Улсын Засгийн Газар, аймаг нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг

4.1.8. б/хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн Газрын өрийн баталгааны дүнг

Эх сурвалж: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

График 8. Засгийн Газрын нийт өр



Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн танилцуулга

Өр, ДНБ-ий харьцаа өндөр байх нь тухайн улсын төлбөрийн чадвар муу, эрсдэл өндөртэй болохыг илтгэдэг. Иймд гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулж, улмаар макро эдийн засгийн тогтвортой бус байдлыг бий болгодог. Тиймээс зээлдэгч орнуудын инфляци болон хүүний түвшин өндөр байх нь элбэг тохиолддог.

Грек улсын хувьд зардлыг их хэмжээгээр тэлснээс гадна дотоодын хувийн хэвслүүдийн ашиг сонирхолыг илүүд үзсэнээс, татварыг нэмж төсвийн орлогыг нэмэгдүүлж чадаагүй нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх шалтгаан болсон. Түүнчлэн төсвийн сахилга батыг сайжруулж, алдагдлыг бууруулах, өрийн тогтвортой байдлыг хангах зорилгоор олон улсын байгууллагуудаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөлгүй төсвийн зардлыг нэмэгдүүлж, төсвөөс гадуурх санхүүжилт хийж байсан нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж хямралын хүнд байдалд хүргэсэн байдаг.

Монгол Улсын төсвийн алдагдал үргэлжилж, улсын өрийн хэмжээ одоогийн өндөр түвшнээсээ нэмэгдэх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулж эдийн засгийн хямрал руу хөтлөх эрсдэл өндөр байна.



2.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ДОТООД ӨРИЙН БАЙДАЛ

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын Засгийн Газар дотоодын зах зээл дээр богино болон урт хугацаат, гадаадын зах зээл дээр урт хугацаат бондуудыг гаргаж ирсэн ба Олон улсын хөрөнгийн захаас 2012-2016 оны хооронд нийт 4 удаагийн үнэт цаас гаргалтаар 2 тэрбум ам.доллар, 1 тэрбум юань босгосон байдаг. Мөн Олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудын хөнгөлөлттэй зээлийг тогтмол авч ирсэн. Дараах графикт 2011-2017 оны хооронд Засгийн Газрын авсан зээлийн хэмжээ болон зээлийн үйлчилгээний төлбөр, зээлийн үйлчилгээний төлбөрийн /нийт хүүгийн төлбөр/ төсвийн алдагдалд эзлэх хувийг харуулав.

Сүүлийн 3 жилд нэгдсэн төсвийн алдагдлын 50+ хувийг зээлийн үйлчилгээний төлбөр эзлэж байгаа ба гадаад дотоодын зах зээлээс босгосон зээлээр зээлийн үйлчилгээний төлбөр болон үндсэн зээлийг гүйцэтгэж ирсэн гэж харж болохоор байна.

2017 оны төсвийн төсөлд тусгаснаар 3Г нийт 7.6 их наяд төгрөгийн дотоод гадаадын зээл авах ба үүний 69 хувийг Засгийн Газрын өрийн үндсэн төлбөр төлөхөд, үүн дотроо 50%-ийг дотоодын зах зээл дээр гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрийг төлөхөд, 33 орчим хувийг төсвийн алдагдал санхүүжүүлэхэд зарцуулах дүр зураг харагдаж байна. 2017 оны төсвийн төсөлд тусгасан шинээр авах зээлийн 71% буюу 5.4 их наяд төгрөгийг дотоодын зах зээл дээр үнэт цаас гаргах замаар босгох төлөвтэй байна. Зээлийн үйлчилгээний төлбөрийн төсвийн алдагдалд эзлэх хувь энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24%, ирэх оны төсвийн алдагдлын 52%-ийг бүрдүүлж байгаа нь төсөвт дарамт болж байна.


График 9. 2010-2017 оны хооронд ЗГ-ын гаргасан нийт бонд, зээлийн үйлчилгээний төлбөр /их наяд төг/



Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн танилцуулга

2017 оны төсвийн төсөлд танилцуулсан 2017 оны төсөөлөлд тусгагдсан Засгийн Газрын зээлийг задлан авч үзвэл дараах байдалтай байна.

График 10. 2017 онд шинээр авах зээлийн байдал /төгрөг/



Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл

**** төсвийн төсөлд олон улсын зах зээл дээрээс босгох 1.3 их наяд төгрөгийг Засгийн Газрын үнэт цаас гаргах эсвэл Олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй зээл авах, арилжааны зээл авах аль нь болохыг тодорхой зааж өгөөгүй ба олон улсын зах зээлд үнэт цаас гаргах нь өндөр хүүтэй байх магадлал их байгаа билээ. 2016 оны 4 сард олон улсын зах зээлд гаргасан Засгийн Газрын үнэт цаасны хүү 10.88% буюу Чингис бондын хүүнээс даруй 2 дахин өндөр байсан.**

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх өөр нэг эх үүсвэр нь: “Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2-р зүйлд зааснаар 2017 онд 160 тэрбум төгрөг, 2018 онд 100 тэрбум төгрөг, 2019 онд 50 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус шилжүүлнэ” гэж заасны дагуу ирэх оны төсөвт төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж 160 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сангаас шилжүүлэхээр тусгасан. Мөн хүний хөгжил сангийн авлага (ирээдүйн өв сан) 48.2 тэрбум төгрөг байна.


Төсвийн төсөлд 2018 оны 1 сард төлөгдөх 500 сая ам.доллар, 6 сард төлөгдөх 1 тэрбум юанийн гадаад бондын үндсэн төлбөрийг төлөх хуримтлал бий болгохоор тусгагдаагүй зэрэг нь 500 сая ам.долларын Чингис бонд, 1 тэрбум юанийн Дим Сам бондын үндсэн төлбөрийн төлөлт дээр хүндрэл үүсэх эрсдлийг нэмэгдүүлж байна.

А. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

2016 оны ХБГ-ээр дотоодын зах зээлд арилжсан Засгийн Газрын үнэт цаасны үлдэгдэл 5.2 их наяд төгрөг буюу Засгийн Газрын нийт өрийн үлдэгдлийн 23%-ийг эзлэж байгаа бол 2017 оны төсвийн төсөлд тусгаснаар ирэх онд 5.4 их наяд төгрөгийн бонд гаргаж 2017 оны төсөөллөөр ЗГ-ын дотоод үнэт цаасны үлдэгдэл нийт өрийн 27%-д хүрэх хүлээлттэй байна. Өмнөх онуудын төсвийн алдагдал дотоодын зах зээлд арилжсан үнэт цаасны харьцааг харахад дотоодын зах зээл дээр арилжигдах Засгийн Газрын бондоор төсвийн алдагдалыг нөхөхөөс илүүлтэйгээр өмнөх үеийн үнэт цаасны төлбөрүүдийг гүйцэтгэж ирсэн байна.


Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт

График 11. Дотоодод гаргасан ЗГҮЦ



Эх сурвалж: Засгийн газрын өрийн мэдээлэл, Сангийн яамны тайлан


График 12. Дотоодын зах зээлд арилжсан үнэт цаас төсвийн алдагдалын харьцаа



Эх сурвалж: Сангийн яамны өрийн мэдээлэл, 2017 оны төсвийн төсөл, судалгааны багийн тооцоолол

Төсвийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр дорвитой ажлууд хийхгүй, төсвийн сахилга батыг чангатгахгүй байх тохиолдолд дотоодын зах зээл дээр 3Г-ын үүсгэж буй өрийн хэмжээ буурах төсөөлөл харагдахгүй байна. Өмнөх өрөө шинээр дотоод бонд гаргах замаар төлөх байдлаар цааш үргэжлэх тохиолдолд 3Г-ын гадаад өрөөс илүүтэйгээр дотоод өрийн дарамтад орох магадлал өндөр байна. (Зээлийн үйлчилгээний төлбөрт дотоодын зээлийн үйлчилгээний төлбөрийн эзлэх хувь 60-с дээш хувийг эзлэж байна) Учир нь дотоодын зах зээлд төдийлөн урт хугацаат үнэт цаас арилжигдаггүй мөн дотоод үнэт цаасны хүү хэт өндөр байгаа зэрэг нь төлбөрийн дарамтыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

График 13. Засгийн Газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй




боломж бүрдэх юм.

Төсвийн сахилга бат, төсвийн төлөвлөлтийг оновчтой хэрэгжүүлсэнээр ЗГ-ын гадаад өрийн нөхцлийг өөрчлөх, зээлжих зэрэглэл, төлөвөө өсгөснөөр олон улсын зах зээлээс урт хугацаат, хүү бага эх үүсвэрийг босгох боломж бүрдэх юм.

Улмаар дотоодын өндөр хүүт, хугацаа богино үнэт цаасны төсөвт учруулж буй дарамтыг бууруулснаар Засгийн Газрын өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх ачааллыг урт хугацаанд жигдлэх, өрийн үйлчилгээний тухайн жилийн төсвийн орлогод эзлэх хувийг бууруулах, Засгийн Газрын өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах

График 14. Дотоод, гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийн харьцаа



Эх сурвалж: ЗГ-ын өрийн мэдээлэл, Сангийн яам; 2017 оны төсвийн төсөл


Б. ГАДААД ӨР

Монгол Улсын нийт гадаад өр 2010 оны эцэст 5.9 тэрбум ам.доллар байсан бол 2016 оны 3-р улирлын байдлаар 23.4 тэрбум ам.долларт хүрээд байна. Өнгөрсөн 6 жилийн CAGR

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт

25.89% байна. Засгийн Газрын гадаад өрийн өсөлтийг авч үзвэл 2011-с 2012 онд 94%-иар өссөн ба энэ нь Олон улсын зах зээлд гаргасан Чингис бондын нөлөө юм.

График 15. Улсын нийт гадаад өр




Эх сурвалж: Монгол улсын гадаад өрийн тойм, Монгол банк 2016

Гадаад үнэт цаасны эргэн төлөлт

Монгол улс 2012 оноос хойш олон улсын зах зээлд 3 удаа үнэт цаас гаргасан ба ирэх 2018, 2021, 2022 онуудад үндсэн төлбөрийн төлөлт хийгдэх хуваарьтай байна. Эдгээр үндсэн төлбөрүүд нь ирэх жилүүдэд төсөвт өрийн ачааллыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байна.

2021, 2022 онд хугацаа дуусах үнэт цаасуудын төлбөрийг төлөх хөтөлбөр, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж жил бүрийн төсөвт тусгаж явах нь оновчтой болно.

График 16. Засгийн Газрын гадаад үнэт цаасны эргэн төлөлт



2012/12 сард Монгол улс олон улсын зах зээл дээр бонд гаргаж 4.13%, 5.13% хүүтэйгээр 1.5 тэрбум ам.доллар босгож байсан бол 3 жилийн дараа 10.88% хүүтэйгээр 500 сая ам.долларын бонд арилжсан байна. Хүүгийн түвшин 2 дахин нэмэгдсэн. Ирэх онд олон улсын зах зээлд бонд гаргах хамгийн доод хүү 10% байх төлөвтэй байна.

- 2012 он 500 сая ам.доллар, 4.13%, 5 жил
- 2015 он 1 тэрбум юанийн Дим Сам бонд, 7.5%, 3 жил

- 2016 он 500 сая ам.доллар, 10.88%, 5 жил

- 2012 он 1000 сая ам.доллар, 5.13%, 10 жил

Эх сурвалж: ЗГ-ын өрийн мэдээлэл, Сангийн яам; Судалгааны багийн тооцоолол

В. ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА

2016 оны 10 сарын байдлаар хүснэгт дор дурьдсан этгээдүүдийн гадаад зээл болон бондод баталгаа гаргасан байна. Засгийн Газрын гаргасан баталгааны үлдэгдэл 2016 ХБГ-р 5.3 их наяд төгрөг, 2017 оны төсвийн төсөлд туссанаар 3.7 их наяд төгрөгт хүрэх тооцоолол байна.

Хүснэгт 1. Засгийн Газрын өрийн баталгааны мэдээлэл


№	Баталгаа гаргуулагч	Он	Хэмжээ	Дуусах хугацаа	Хүү
1	Хөгжлийн банк /гадаад үнэт цаас/	2012	580.0 сая ам.дол	2017	5.75%
2	МИАТ ТӨХК /ЭКСИМ банкны зээл/	2013	77.4 сая ам.дол	10 жил	2.52%
			23.9 сая ам.дол	7 жил	5.35%+LIBOR 3m
			20 сая ам.дол	5 жил	9.38+LIBOR 3m
3	Хөгжлийн банк /Самурай бонд/	2014	30.0 тэрбум иен	2024	1.52%
4	Хөгжлийн банк /Credit Suisse-ийн зээл/	2014	300.0 сая ам.дол	7 жил Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа – жил	4.37%+LIBOR
5	Хөгжлийн банк /БНХАУ-ын зээл/	2014	162.0 сая ам.дол	8 жил Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил	6%
6	Хөгжлийн банк/ОХУ-ын ВТБ банк	2016	300.0 сая ам.дол	3 жил	LIBOR+5.75%
7	Алтны компаниуд	2016	2.7 тэрбум төг	2016.12	
8	Эрдэнэс Монгол / АХБ	2016	35 сая ам.дол	15 жил 3 жил үндсэн болон зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөнө	LIBOR

Эх үүсвэр: ЗГ-ын өрийн мэдээлэл, Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГААНЫ ЭРГЭН ТӨЛӨЛТ

Засгийн Газрын баталгааны эргэн төлөлтийг харуулсан дараах графикт Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын үнэт цаас, 30.0 тэрбум иений Самурай бонд, Кредит Свисс банкны 300.0 сая ам.долларын зээл, Хятадын Хөгжлийн банкны 162.0 сая ам.долларын зээл, мөн “МИАТ” ТӨХК-ийн 121.4 сая ам.долларын экспортын зээл тус тус багтаж тооцоологдсон ба 2016 онд Засгийн Газрын гаргасан Хөгжлийн банк/ОХУ-ын ВТБ банк 300.0 сая ам.дол, Эрдэнэс Монгол / АХБ 35 сая ам.дол, Алтны компаниуд 2.7 тэрбум төгрөгийн баталгаанууд орж тооцоогдоогүй болно.

График 17. Засгийн Газрын баталгаа бүхий зээллэгийн эргэн төлөлт /сая ам.доллар/




Эх үүсвэр: ЗГ-ын өрийн мэдээлэл, Сангийн яам

2.3 2017 ОНД ШИНЭЭР АВЧ БУЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн төсөлд тусгагдсанаар 117 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилт болох 857.7 тэрбум төгрөгийг гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар шийдэхээр төлөвлөсөн байна. Үүний хэрэгжиж байгаа болон шинээр хэрэгжүүлэх нийт 74 төсөл хөтөлбөрт 723.1 тэрбум төгрөгийн гадаадын хөнгөлөлттэй зээл авах ба эдгээр хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг авч үзвэл БНХАУ-ын ЭКСИМ банкны санхүүжилт нийт санхүүжилтын 34%, Японы Засгийн Газар болон Жайка 25%, 21%-ийг АХБанк санхүүжүүлж байна.

График 18. 2017 онд шинээр болон үргэлжлүүлэн авах хөнгөлөлттэй зээл




Ирэх онд шинээр эхлүүлэх 28 төсөл хөтөлбөрт нийт **224.4 тэрбум** төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг шинээр авна. Үүний **65%-ийг** БНХАУ-ын ЭКСИМ банк санхүүжүүлнэ.

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн танилцуулга

ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

График 19. Нийт ЗГ-ын өрийн үйлчилгээ ба өрийн үйлчилгээний ДНБ болон тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь /тэрбум төгрөг/



Эх сурвалж: ЗГ-ын өрийн мэдээлэл, Сангийн яамны тайлан; 2017 оны төсвийн төслийн танилцуулга

2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ЗГ-ын нийт өрийн үйлчилгээний ДНБ-д эзлэх хувь 21%-д хүрэхээр хүлээгдэж байгаа бол 2017 оны төсөөлөлөөр 20%-д хүрэхээр байна. 2016 онд төлөгдөх хүүгийн төлбөр төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 20%, 2017 онд 23%-д хүрэхээр тооцоологдсон байна. Сүүлийн жилүүдэд нийт өрийн үйлчилгээний төлбөр улсын тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь үлэмж нэмэгдэж байгаа ба энэ нь төсөвт ирэх өрийн дарамтыг улам нэмэгдүүлж, өрийг өрөөр хаах сонголтыг үлдээх, улмаар санхүүжилтын зардал өсөх, өрийн дарамт гүнзгийрэх нөхцлийг бүрдүүлэх эрсдэл өндөр байна.

2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гадаад өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд

ОУВС, Дэлхийн банкнаас улсын гадаад секторын өрийн тогтвортой байдлын 5 шалгуур үзүүлэлтийг тогтоож, эдгээр үзүүлэлтээр улс орны өрийн хүндрэлийн эрсдэлийг тооцдог. Эдгээр үзүүлэлтийг тооцоход ашиглаж буй улсын гадаад секторын өрд Засгийн Газар, орон нутгийн болоод төв банкны гадаад зээллэг болон тэдгээрийн гаргасан өрийн баталгааг хамруулан ойлгодог бөгөөд 2014, 2015 оны жилийн эцсийн байдлаарх үзүүлэлтийг дор харуулав. Манай улсын бодлого институцийн үнэлгээ (CPIA) 3.4 буюу хэвийн гэсэн ангилалд багтаж байгаа ба энэхүү ангилалд харгалзах гадаад өрийн сэрэмжлэх түвшинг Дэлхийн банк болон Олон улсын валютын сан тогтоож өгсөн байдаг.

Хүснэгт 2. Гадаад өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Сэрэмжлэх түвшин	2013	2014	2015
Гадаад өр (ӨҮЦ) / ДНБ	40%	34.7%	46.3%	52.1%
Гадаад өр (ӨҮЦ) / Экспорт	150%	77.0%	99.1%	129.0%
Гадаад өр (ӨҮЦ) / Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	250%	103.6%	162.6%	201.9%
Гадаад өрийн үйлчилгээ / Экспорт	20%	2.9%	4.9%	5.0%
Гадаад өрийн үйлчилгээ / Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	30%	3.9%	8.1%	7.8%

Эх сурвалж: Монгол улсын гадаад өрийн тойм, Сангийн яамны тайлан

Нийтлэг жишгийн дагуу эдгээр 5 үзүүлэлтээс 3 нь хангагдаагүй тохиолдолд тухайн улсыг өрийн хүндрэлийн эрсдэлтэй гэж үздэг бөгөөд дээрх тооцооллоос харахад манай улсын хувьд 4 үзүүлэлтийг бүрэн хангаж байгаа юм. 2017 оны төсөвт гадаадаас нэмэлтээр 1.3 их наяд төгрөгийн зээл авахаар тусгасан байгаа нь гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх магадлал өндөр байна.

Засгийн Газрын нийт өрийн дарамтын үзүүлэлтүүд

Хүснэгт 3. Засгийн Газрын нийт өрийн дарамтын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2016	2017	2018	2019
Засгийн Газрын нийт өр (ӨҮЦ) / ДНБ	88%	85%	80%	75%
Засгийн Газрын нийт өр (ӨҮЦ) / Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	396%	372%	342%	330%
Нийт ЗГ-ын өрийн үйлчилгээ / Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	94%	88%	120%	

Эх сурвалж: Судалгаан багийн тооцоолол

Мөн Дэлхийн банк Олон улсын валютын сангийн санал болгодог Засгийн Газрын нийт өрийн тогтвортой байдлыг хэмжих дээрх 3 үзүүлэлт байдаг ба уг аргачлалын дагуу тооцоолол хийж үзэхэд ЗГ-ын нийт өрийн төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь 88%, хэрэв 2017 онд хугацаан дуусаж буй МУХБ-ын 580 сая ам.долларын евро бондыг ЗГ төлөхөөр тооцвол энэ харьцаа 107%-д хүрэх тооцоолол байна. Өрийн үйлчилгээ төсвийн орлогын харьцаа ирэх онуудад өндөр байгаа нь Засгийн Газар өрөө шинэчлэх эсвэл өөр эх үүсвэрийн зээлээр өмнөх өрөө дарахаас өөр сонголтгүй байгаа нь харагдаж байна. Энэ тохиолдолд хүүгийн зардал өсөх ба өрийн дарамт нэмэгдэх өндөр эрсдлийг дагуулж байна.

Зээлжих зэрэглэл ба түүний нөлөөлөл

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоодог томоохон агентлагууд энэ онд манай улсын зэрэглэлийг өндөр эрсдэлтэй ангилалын хамгийн доод үнэлгээ рүү нэг шат бууруулсан. Мүүдс агентлаг 2005 онд анх манай Засгийн Газрын зээлжих зэрэглэлийг В1 ангилалд оруулан тогтоосон бөгөөд хэтийн төлөвийг тогтвортой гэж үнэлж байсан. 2014 оноос хойш зээлжих зэрэглэл жил бүр тогтмол буурч тогтож байгаа ба Мүүдс манай Засгийн Газрын зээлжих зэрэглэлийг В3 ангилалд, хэтийн төлөвийг сөрөг гэж тогтоогоод байна.

Хүснэгт 4. Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ

	2014.11	2015.11	2016.10
S&P	B+ тогтвортой	B+тогтвортой	B- тогтвортой
Moody's	B2 сөрөг	B2 сөрөг	B3 сөрөг
Fitch	B+сөрөг	B+ сөрөг	B тогтвортой

Эх сурвалж: www.tradingeconomics.com

Зээлжих зэрэглэл буурах нь Засгийн Газрын санхүүжилт босгох зардлыг нэмэгдүүлж байдаг.

Хүснэгт 5. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ ба зээлжих зардлын доод жишиг

Moody's rating	Fitch rating	Default spread (bps)
Aaa	AAA	0
Aa1	AA+	25
Aa2	AA	50
Aa3	AA-	70
A1	A+	85
A2	A	100
A3	A-	115
Baa1	BBB+	150
Baa2	BBB	175
Baa3	BBB-	200
Ba1	BB+	240
Ba2	BB	275
Ba3	BB-	325
B1	B+	400
B2	B	500
B3	B-	600
Caa	CCC	700
Ca	CC	850
C	D	1,000

Source: Modified from Damodaran (2012)


Манай ЗГ-ын зээлжих зэрэглэлийг Мүүдс B2-с B3 болгож бууруулах нь олон улсын зах зээл дээрээс татах санхүүжилтын зардлыг 100bps буюу 1%-иар шууд нэмэгдүүлдэг гэсэн судалгаа байна. Гэхдээ энд хөрөнгө оруулагчийн хүсэл, эрсдлээс айх түвшин, тухайн улсын улс төр, ЗГ-ын чадварлаг байдал зэрэг олон зүйлээс хамаарч тухайн улсын үнэт цаасны хүү тогтдог. Эндээс үзэхэд улс орнуудын зээлжих зэрэглэл буурах нь олон улсын зах зээл дээрх санхүүжилтын зардлыг нэмэгдүүлдэг.

3. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

2017 онд гадаад зээл, буцалтгүй тусламжаар 111 төслийг 857.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсний 723.1 тэрбум төгрөг нь зээл, үлдэх хэсэг нь буцалтгүй тусламж байна. Уг зээлийн 224.4 тэрбум нь 2017 он шинээр авч буй зээл байна.


Дээр дурьдсан 111 төслийн хамгийн олон буюу 27 нь дэд бүтцийн салбарт зориулагдаж байгаа төдийгүй нийт санхүүжилтийн 49 хувийг зарцуулж байна. Харин байгал орчны чиглэлийн төслүүд тооны хувьд харьцангуй олон боловч санхүүжилтийн хэмжээ эрс бага байдаг байна. Боловсрол, шинжлэх ухаан, Хөдөө аж ахуй, ядуурлыг бууруулж ажлын байр нэмэгдүүлэх, Нийтийн үйлчилгээ зэрэг бусад салбарын төслүүдийн тоо болон санхүүжилт харьцангуй жигд хуваарилагджээ.

График 20. Гадаадын зээл, тусламжийн хөтөлбөрийн тоо салбараар



Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Судалгааны багийн тооцоолол

График 21. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилт салбараар




Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Судалгааны багийн тооцоолол

Зээл, тусламжийг санхүүжүүлэгч 23 талаас санхүүжилтийн хэмжээгээр БНХАУ-ын ЗГ болон түүний харьяа байгууллагууд тэргүүлж Япон улс, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк, БНСУ удаалж байна. Гэхдээ БНХАУ-ын санхүүжүүлж буй зээл, тусламжийн 51 хувь нь (мөнгөн дүнгээр) тус улсын Эксим банкнаас шинээр авч буй зээл юм. АХБ, ДБ зэрэг доноруудын зарим улсын Засгийн Газартай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийг тусад нь авч үзсэн болно.

Зээл, тусламжийн төслүүдийн тоо болон санхүүжилтийн хэмжээг харьцуулж үзвэл Япон улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй нэг төслийн дундаж санхүүжилт хамгийн их буюу ойролцоогоор 26 тэрбум төгрөг байна.

График 22. Зээл тусламжийн хөтөлбөрийг санхүүжүүлэх улс орон, олон улсын байгууллагууд (сая.төгрөг)



Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Судалгааны багийн тооцоолол

Салбар тус бүрт хэрэгжүүлж байгаа төслүүдийг санхүүжилтийн хэмжээ, санхүүжүүлэгчээр нь ялган харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Салбар тус бүрт хэрэгжүүлж байгаа төслүүдийг санхүүжилтийн хэмжээ, санхүүжүүлэгч

	БО	БСШУ	Дэд бүтэц	ЖДУ	Засаглал	Нийгмийн халамж	Нийтийн үйлчилгээ	Олборлох	ОН Хөгжил, хот байгуулалт	Тодорхойгүй	Төрийн үйлчилгээ	ХАА	ЭЗ санхүү	ЭМ	Ядуурлыг бууруулах, ажил эрхлэлт	Grand Total
Австри			9,291							6,317						15,608
АХБ	1,454	12,540	45,218			5,170	16,598		18,474		7,590	20,260	8,467	14,821	8,344	158,935
АХБ, Япон															2,868	2,868
Бельги														1,000		1,000
БНСУ		19,196	13,202		13				966					10,942		44,319
БНФУ														150		150
БНХАУ	2,650	38,363	164,611		889	12,199			25,319	13,160		18,662			11,500	287,353
ДБ		12,808	2,364		6,874		528	11,605	7,425			6,238	5,662	8,934	846	63,284
Б, Швейцарь															11,450	11,450
ЕСБХБ									9,583							9,583
ЕХ					3,136										7,387	10,523
ЕХ, Чех		89													680	769
Кувейт			4,669											10,400		15,069
НУБ	7,177															7,177
Польш										1,104						1,104
Унгар												5,750				5,750
Франц			374													374
ХААХОУС												4,559				4,559
ХБНГУ	5,820		9,200													15,020
Чех	745															745
Швейцарь								3,000	444							3,444
Энэтхэг		9,550	6,001													15,551
Япон		16,228	164,925	1,443									445			183,041
Grand Total	17,847	108,775	419,855	1,443	10,912	17,369	17,125	14,605	62,211	20,581	7,590	55,469	14,573	46,247	43,075	857,678

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Судалгааны багийн тооцоолол


БНХАУ-ын зээл, тусламжийн дийлэнхи буюу 57 хувь дэд бүтцийн салбарт, 13 хувь боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт, 9 хувь орон нутгийн хөгжил, хот

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт

байгуулалтын салбарт чиглэж байна. Япон улсын зээл, тусламжийн 90 хувь дэд бүтэц, 10 орчим хувь боловсролын салбарт чиглэж байгаа бол Дэлхийн банкны зээл, тусламжийн 20 орчим хувь боловсролын салбарт харин АХБ-ны санхүүжилтийн 28 хувь дэд бүтэц, 12 хувь хот байгуулалтын чиглэлээр зарцуулагдахаар байна.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төсвийн ерөнхийлөн захирагчдын байдлыг авч үзвэл Зам, тээврийн хөгжлийн сайд хамгийн их буюу 259.7 тэрбум төгрөгийн зээл тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлж түүний дараа Улаанбаатар хотын захирагч (109.5 тэрбум), БСШУ-ы сайд (108.7 тэрбум), Сангийн сайд (106.7 тэрбум) орж байна.

График 23. Зэл тусламжийн хөтөлбөрүүдийн санхүүжилт төсвийн ерөнхийлөн захирагчдаар



Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны төсвийн төсөл. Судалгааны багийн тооцоолол

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ТӨСӨЛ 2017. Монгол улсын 2017 оны төсвийн танилцуулга. УБ: Засгийн газар
ДЭЛХИЙН БАНК 2016. Монгол улсын макро эдийн засгийн төлөв. Судалгааны ажил
СЯ 2016. Засгийн газрын өрийн мэдээлэл, улирлаар
Монголбанк 2016. Монгол улсын гадаад өрийн тойм
Moody's 2016. Countries credit rating. Tradingeconomics.com
IMF 2015. World Economic Outlook International Monetary Fund.
Д.Баярмаа, П.Хишигбаяр 2015. Монгол улсын 2016 оны төсвийн төсөлд хийсэн тойм
шинжилгээ УБ: ННФ
СЯ 2015. Монгол улсын өрийн талаарх мэдээлэл. Ерөнхий сайдын мэдээлэл



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВЛӨЛ

www.financemongolia.com

2016 он

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн Тогтвортой байдал, Өрийн удирдлагын тойм дүгнэлт